

6. Хог хаягдал, ус дулаан, цахилгааны өр төлбөргүй байх.

3.1.3 Сумын Засаг Даргын “Баярын бичиг”

Байгууллага, салбарын ой, бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн амжилт гаргаж, хамт олноо хошуучлан тухайн салбартай З аас доошгүй жил тогтвортой суурьшилтай ажилласан хүмүүсийг сумын Засаг даргын “Баярын бичиг” -ээр шагнана.

3.2 Дээрх шагналуудаас гадна Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.3-д заасны дагуу бөхчүүдэд “Начин”, “Заан” цол, харваачдад сумын “Мэргэн”, “Гарамгай харваач”, “Гоц харваач” цол олгох ба Үндэсний Их баяр наадамд амжилт үзүүлсэн бөх, уяач, харваачдад Монгол Улсын Засгийн газрын 2010 оны “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоо тухай” 271 дүгээр тогтоолын дагуу мөнгөн шагналыг олгоно.

3.3 Онцгой гавьяа байгуулсан тохиолдолд сумын Засаг даргын шагналыг ажилласан жил харгалзахгүй олгож болно.

3.4 Нэг төрлийн шагналыг давхардуулан олгохгүй.

3.1.4 Сумын “Аварга малчин өрх”

Эрчимжсэн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, малын ашиг шимиийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өсгөх болон нийгэмд оруулж байгаа малчдын хувь нэмрийг үнэлж дараахь шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын ажлын үзүүлэлтийг үндэслэн сумын Аварга малчин -аар жил бүр 3 –аас дээшгүй иргэнийг шалгаруулна. Үүнд

Мал сүргээ эрүүлжүүлэх халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан эрүүл сүрэгтэй болсон байна.

Бодод шилжүүлснээр 100-аас доошгүй малтай байх бөгөөд хонин сүрэгт эзлэх ямаан сүргийн тоо 30 %-аас ихгүй, оны эхний 100 хээлтэгч тутмаас бойжуулсан төлийн тоо тухайн жилийн сумын дунджаас илүү, малын зүй бусын хорогдолгүй байна.

Жил бүр өөрийн малын тоо толгойд ноогдох хэмжээгээр өвс тэжээл бэлтгэж нөөцөлсөн байх

Үржилд ашиглаж байгаа хээлтэгч нь мал үржлийн нэгж албаар баталгаажсан байх

Малын үүлдээр угсааг сайжруулсан байна.

Отор нүүдэл хийж, цаг үеийн хүнд нөхцөлд бэлчээр нөөцлөн нийт мал сүргээ тарга хүч авахуулсан байх.

Малчны бүлэг хоршоонд нэгдэн мал аж ахуйн болон бусад чиглэлээр өрхийн үйлдвэрлэл эрхэлж 1-ээс доошгүй байнгын болон түр ажлын байр бий болгосон байх.

Малгүй өрхийг малжуулсан байна.

Сум, баг, олон нийтийн арга хэмжээ, хурал зөвлөгөөнд идэвхтэй оролцож иргэний үүргийн болон захиргааны зөрчилгүй байна. /татвар, нийгмийн даатгал, хураамж/

3.1.5 Сумын “Алдарт уяач”

Сумын баяр наадмын хурдан морины уралдаанд хурдан морь нь 6 удаа түрүүлсэн эсхүл 12 удаа айрагдсан уяачид сумын алдарт уяач цол олгоно.

3.1.6 Сумын “Тэргүүний газар тариаланч”

1. Газар тариалангийн үйлдвэрлэлд сүүлийн 3 жилд дараалан жил бүр га тутмаас хураан авсан үр тарианы ургац нь өсөлттэй байх, усалгаатай талбай 30 цн-ээс доошгүй байх, төмс хүнсний ногооны ургац га-аас 15 тонноос дээш байх..

2. Үр тарианы төмс хүнсний ногоо үйлдвэрлэл эрхлэгчдийн эргэлтийн талбайн ашиглалтыг харгалзах.

3. Улс, аймаг, орон нутгийн татварын орлогын бүрдүүлэлтэд хариуцлагатай хандаж хуулийн хугацаанд татварыг төлдөг байх.

4. Хөрсний үржил шимийг хамгаалах талаар тодорхой ажил хийсэн байх.

3.1.7 Сумын “Тэргүүний сурагч”

Сурлагын үнэлгээгээр “А” үнэлгээтэй суралцаж байгаа, сургуулийнхаа шилдэг сурагчаар шалгарсан, дараахи шалгуур үзүүлэлтийг хангасан сурагчид нэр дэвшинэ.

1. Судалж байгаа хичээлээрээ аймаг, сум, бүсийн хэмжээнд зохион байгуулагдаж буй хичээлийн олимпиадад медальт байр улсын хэмжээнд зохион байгуулагдсан олимпиадад медальт байр болон шагналт байрт шалгарсан байх.

2. Сумын хэмжээнд зохиогдсон спорт, урлагийн тэмцээн уралдаанд хувийн болон багийн амжилтаар медальт байрт шалгарсан байх.